



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/439

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг  
шинээр олгох тухай


Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.7, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсрол шинжлэх ухааны газрын дүгнэлтийг үндэслэн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын тавдугаар сургуулийг шинээр байгуулахаар болсонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг шинээр олгосугай.

2.Сургалтын үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу чанар, хүртээмжтэй зохион байгуулахыг тус сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (С.Мөнхтуяа)-д, удирдлага зохион байгуулалт, арга зүйгээр хангаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (С.Мөнхцэцэг)-д тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ